



Inter-Parliamentary Union

For democracy. For everyone.

# Жендерийн мэдрэмжтэй Парламентын үйл ажиллагааны төлөвлөгөө

Зохиогчийн эрх © ОЛОН УЛСЫН ПАРЛАМЕНТЫН ХОЛБОО 2017

Бүх эрх хуулиар хамгаалагдсан.

Энэ нийтлэлийн аль ч хэсгийг Парламент хоорондын холбооны урьдчилан зөвшөөрөлгүйгээр хуулбарлах, хайх системд хадгалах, цахим болон электрон байдлаар нийтлэх, олшруулах болон аливаа бусад ямар нэг хэлбэрээр ашиглахыг хориглоно.

Энэхүү нийтлэлийг хэвлэн нийтлэгчдийн урьдчилан зөвшөөрөлгүйгээр арилжааны зорилгоор болон өөр бусад зорилгоор олшруулан тараахгүй бөгөөд дараагийн хэвлэл тухайн шаардлагыг хангасан тохиолдолд хэвлэн нийтэлнэ.

Энэхүү бүтээл болон бүтээлийн хэсгийг хуулбарлах, орчуулах эрх хүссэн өргөдлийг Олон Улсын Парламентын Холбоонд илгээнэ. Парламентын гишүүд болон Парламентын байгууллагууд уг бүтээлийг зөвшөөрөлгүйгээр хуулбарлаж, орчуулж болох хэдий ч энэ талаар Олон Улсын Парламентын Холбоонд заавал мэдэгдэх шаардлагатай.

ISBN: 978-92-9142-861-8

Орчуулсан:	Б.Хангалсайхан
Хянан тохиолдуулсан:	С.Алтанхуяг
Дизайн:	Ч.Цогт-Очир

Монгол хэл дээрх хэвлэл нь Монгол Улсын Их Хурлын Тамгын газар, Швейцарын хөгжлийн агентлагийн хамтарсан “Монгол Улсад парламентын ардчиллыг бэхжүүлэх нь” төслийн дэмжлэгтэйгээр гүйцэтгүүлсэн албан бус орчуулга бөгөөд орчуулгын үнэн зөв байдал, түүнээс үүдсэн хариуцлагыг орчуулагч хариуцна.

“Оргил пресс” ХХК-д эхийг бэлтгэж, хэвлэв.

# Агуулга

<b>1-р хэсэг: Оршил ба зорилго</b>	<b>5</b>
Оршил	5
Зорилго	7
<b>2-р хэсэг: Үйл ажиллагааны төлөвлөгөөний үндсэн чиглэл</b>	<b>8</b>
<b>Үйл ажиллагааны чиглэл 1</b>	
Парламент дахь эмэгтэйчүүдийн тоог нэмэгдүүлэх, оролцооны тэгш байдлыг хангах	8
<b>Үйл ажиллагааны чиглэл 2</b>	
Жендерийн тэгш байдлын тухай хууль тогтоомж, бодлогыг бэхжүүлэх	10
<b>Үйл ажиллагааны чиглэл 3</b>	
Парламентын бүхий л үйл ажиллагаанд жендерийн тэгш байдлыг хангах	13
<b>Үйл ажиллагааны чиглэл 4</b>	
Жендерийн мэдрэмжтэй дэд бүтэц, парламентын соёлыг бий болгох, сайжруулах	16
<b>Үйл ажиллагааны чиглэл 5</b>	
Жендерийн тэгш байдлын талаарх үүрэг хариуцлагыг эрэгтэй, эмэгтэй бүх парламентын гишүүд жигд хуваалцаж байх	18
<b>Үйл ажиллагааны чиглэл 6</b>	
Улс төрийн намуудыг жендерийн тэгш байдлын төлөө тэмцэгч байхыг дэмжих	19
<b>Үйл ажиллагааны чиглэл 7</b>	
Парламентын ажилтнуудын дунд жендерийн мэдрэмж, жендерийн тэгш байдлыг нэмэгдүүлэх	21
<b>3-р хэсэг: Үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт</b>	<b>22</b>
Парламентад жендерийн мэдрэмжтэй шинэчлэлийг санаачлан хэрэгжүүлэх нь	22
Жендерийн мэдрэмжтэй Парламентыг дэмжихэд ОУПХ-ны үүрэг, оролцоо	24
<b>Хавсралт</b>	<b>25</b>



# Жендерийн мэдрэмжтэй Парламентын үйл ажиллагааны төлөвлөгөө

**ОУПХ-ны 127-р Хуралдаанаар батлав  
(Кэбэк хот, 2012 оны 10-р сарын 26)**

## **ОУПХ-ны 127-р хуралдаан**

Жендерийн мэдрэмжтэй Парламентуудын үйл ажиллагааны төлөвлөгөөг гаргахын өмнө ОУПХ-ны гишүүдтэй хийсэн зөвшилцлийн үр дүнд боловсруулан гаргаад буй энэхүү энэхүү баримт бичиг нь бүхий л улс орнуудын нийтлэг нөхцөл байдалд тохирсон тодорхой шийдлүүдийг гаргахын сацуу үндэсний болон бүс нутгийн өвөрмөц нөхцөлд нийцсэн өргөн хүрээний шийдэл, хувилбаруудыг санал болгож, эдгээр нь бүхий л улс оронд жендерийн мэдрэмжтэй парламентыг сайжруулах нийтлэг үндэс суурь болж буйг үндэслэн

1. Жендерийн мэдрэмжтэй Парламентын үйл ажиллагааны хөтөлбөрийг батлахаар шийдвэрлэх;
2. Гишүүн орнуудыг энэхүү үйл ажиллагааны хөтөлбөрийг Парламент болон засгийн газрынхаа анхааралд хүргэж, аль болох өргөн хүрээнд түгээн дэлгэрүүлж, үндэсний хэмжээнд хэрэгжүүлэхийг уриалах;
3. ОУПХ-ны Ерөнхий нарийн бичгийн даргыг энэхүү баримт бичгийг олон улсын түвшинд аль болох өргөн дэлгэрүүлж, хэрэгжилтийг үндэсний хэмжээнд дэмжихэд анхаарлаа хандуулахыг хүсэж байна.



ОУПХ-ны Жендерийн түншлэлийн бүлгээс Жендерийн мэдрэмжтэй Парламентуудын үйл ажиллагааны төлөвлөгөөг 127-р Ассамблейд танилцуулж байна (Квебек хот, 2012 оны 10-р сарын 26).

---

# Оршил

*Ардчилал нь байнгын үнэлэлт, дүгнэлтийг шаарддаг. 20-р зуунд дэлхий даяар ардчилалд гарсан хамгийн том өөрчлөлтүүдийн нэг бол эмэгтэй сонгогч болон эмэгтэй парламентын гишүүдийн тоо нэмэгдсэн явдал юм.*

Үүний зэрэгцээ жендерийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн эрх мэдлийг нэмэгдүүлэх нь олон улсын улс төр, хөгжлийн хөтөлбөрүүдийн салшгүй нэг хэсэг болж, Мянганы хөгжлийн зорилтууд (МХЗ)-д хүрэх ахиц дэвшил, түүнд хүрэх гол цөм гэдгийн нэг том илрэл болсон. Жендерийн тэгш байдал гэдэг нь эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд тэгш эрх, үүрэг хариуцлага, боломжийг эдэлнэ гэсэн үг юм. Жендерийн тэгш байдал болон эмэгтэйчүүдийн эрхийг хангах нь улс төрийн болон хууль эрх зүйн томъёолол шаарддаг хүний эрхийн нэг хэсэг юм. Улс орнууд жендерийн тэгш байдал болон эмэгтэйчүүдийн эрхийг хангах, хүндэтгэх, хамгаалах ёстой.

Эдгээр зорилтод хүрэхийн тулд тууштай арга хэмжээ авах шаардлагатай. Хэдийгээр зарим арга хэмжээнд улс орнуудын парламентын онцлог болох хувь хүний соёл, нийгэм, шашны нөхцөл байдлыг харгалзан үзэх шаардлагатай боловч ахиц дэвшил нь аливаа нэг хандлага эсвэл ойлголтыг өөрчлөхөд хүргэдэг.

Парламентууд нь жендерийн тэгш байдлыг хангах зорилтыг хэрэгжүүлэхэд маш тохиромжтой. Парламент нь нийгмийн тусгалыг олж харах зорилготой тул сонгогчдынхоо өөрчлөлтийг ч мөн анхаарах шаардлагатай.

Жендерийн мэдрэмжтэй парламент гэж бүрэлдэхүүн, бүтэц, үйл ажиллагаа, арга барилдаа эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хэрэгцээ, ашиг сонирхолд эрх тэгш хариу үзүүлдэг нийцтэй парламентыг хэлнэ. Жендерийн мэдрэмжтэй Парламентууд нь эмэгтэйчүүдийн бүрэн оролцоонд саад болж буй асуудлуудыг шийдэж, нийгэмд эерэг хандлага, үлгэр жишээг нэвтрүүлж байдаг. Тэд өөрсдийн үйл ажиллагаа, нөөц бололцоогоо жендерийн тэгш байдлыг хангах чиглэлд үр дүнтэй ашиглахыг зорьдог.

Жендерийн мэдрэмжтэй Парламентад эмэгтэйчүүдийн оролцоог хангахад бодит, бүтцийн болон соёлын хувьд ямар нэгэн саад бэрхшээлгүй, эрэгтэй, эмэгтэй гишүүд, ажилчид эрх тэгш байх ёстой. Энэ нь зөвхөн эмэгтэйчүүдийн ажиллах боломжтой газар бус ажиллах, хувь нэмэр оруулахыг хүсдэг газар байх хэрэгтэй. Жендерийн мэдрэмжтэй Парламент нь жендерийн тэгш байдлыг хангаж, нийгэмд эмэгтэйчүүдийн эрхийг нэмэгдүүлснээрээ үндэсний хэмжээнд болон олон улсад эерэг жишиг тогтоодог.

Тиймээс жендерийн мэдрэмжтэй Парламент нь орчин үеийн нийгмийн тэгш байдлын шаардлагыг хангаж, тусгадаг Парламент юм. Эцсийн дүндээ энэ нь илүү үр дүнтэй, өгөөжтэй, хууль ёсны Парламент юм.



[Үйл ажиллагааны төлөвлөгөөг ОУПХ-ны 127-р чуулганаар батлав.](#)

---

# Зорилтууд

Энэхүү үйл ажиллагааны төлөвлөгөө нь Парламентуудын жендерийн мэдрэмжтэй болох зорилтыг дэмжих зорилготой болно. Үүний хүрээнд эмэгтэй гишүүдийн тооноос үл хамааран бүхий л Парламент хэрэгжүүлэх боломжтой үйл ажиллагааны долоон чиглэлээс бүрдсэн стратегийг танилцуулж байна.

Парламентууд энэхүү үйл ажиллагааны төлөвлөгөөг өөриймшүүлж, үндэснийхээ онцлогт таарсан тодорхой зорилт, арга хэмжээ, эцсийн хугацааг тогтоож, төлөвлөгөөг хэсэгчлэн эсвэл бүхлээр нь хэрэгжүүлэхийг уриалж байна. Мөн жендерийн мэдрэмжтэй болох зорилгод хүрэх ажлын явцдаа тогтмол хяналт тавьж, дүгнэлт хийж байхыг хүсэж байна.

Жендерийн мэдрэмжтэй Парламент нь өөрийн бүтэц, үйл ажиллагаа болон арга барилдаа эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хэрэгцээ, ашиг сонирхолд нийцүүлэн ажилладаг.

## Жендерийн мэдрэмжтэй Парламент нь:

1. Бүх хэлтэс, алба болон дотоод бүтэцдээ эмэгтэйчүүд болон эрэгтэйчүүдийн тооны тэгш байдлыг хангахыг зорьж, дэмжиж ажилладаг.
2. Жендерийн тэгш байдлын бодлогын тогтолцоог өөрийн үндэсний Парламентын онцлогт тохируулан хөгжүүлдэг.
3. Бүхий л түвшинд жендерийн тэгш байдлыг хангахыг эрхэмлэдэг.
4. Эмэгтэйчүүдийн эрхийг хүндэтгэж, жендерийн тэгш байдлыг дэмжиж, Парламентын эрэгтэй, эмэгтэй гишүүдийн хэрэгцээ, бодит байдалд нийцүүлэн ажил, гэр бүлийн үүрэг хариуцлагыг тэнцвэржүүлэх дотоод соёлыг төлөвшүүлдэг.
5. Жендерийн тэгш байдлыг хангахад эрэгтэй гишүүдийн оруулж буй хувь нэмрийг үнэлж, түүнд тулгуурладаг.
6. Жендерийн тэгш байдлыг хангахад улс төрийн намуудын идэвхтэй оролцоог хөхүүлэн дэмждэг.
7. Жендерийн тэгш байдлыг хангахад Парламентын ажилчдыг боломж, нөөцөөр хангаж, эмэгтэйчүүдийг удирдах албан тушаалд томилох, уг албан тушаалд үлдэхийг дэмжин Парламентын бүхий л үйл ажиллагаанд жендерийн тэгш байдал хангагдаж байгаад хяналт тавьж ажилладаг.

## Үйл ажиллагааны чиглэл 1

# Парламентад эмэгтэйчүүдийн тоог нэмэгдүүлж, тэгш оролцоог хангах

*Оролцооны хувьд тэгш байх нь жендерийн мэдрэмжтэй өөрчлөлтийг амжилттай хэрэгжүүлэх гол хүчин зүйл юм.*

### Парламент дахь оролцоо

20-р зууны дунд үеэс эхлэн Парламент дахь эмэгтэйчүүдийн тоо аажмаар нэмэгдэж байгаа ч энэ нь нийгэм дэх эмэгтэйчүүдийг бүрэн төлөөлж чадахгүй хэвээр байна.

Жендерийн мэдрэмжтэй өөрчлөлтөөр дамжуулан Парламент дахь эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх нь эмэгтэй гишүүдийн тоог нэмэгдүүлээд зогсохгүй жендерийн мэдрэмжтэй байх зарчмуудыг хэрэгжүүлэхэд түлхэц болно.

Энэхүү тэнцвэргүй байдлыг арилгахын тулд Парламентууд дараах арга хэмжээнээс хамгийн багадаа нэг эсвэл хэд хэдэн арга хэмжээг хэрэгжүүлбэл зохино. Үүнд:

- Улс орныхоо нөхцөл байдалтай уялдуулан намуудаас олон эмэгтэйчүүд “ялах боломжтой” суудалд өрсөлдөх, сонгуулийн тухай хууль болон үндэсний хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах тухай санал гаргах
- Эмэгтэй нэр дэвшигч болон парламентын гишүүний эсрэг хүчирхийллийн шинжтэй үйлдлийг буруушаах, үүнээс урьдчилан сэргийлэхийн тулд хууль эрх зүйн болон бодит арга хэмжээ авах
- Парламент дахь эмэгтэйчүүдийн төлөөллийн ач холбогдлын талаар ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх компани ажил явуулах
- Менторын хөтөлбөрийг дэмжиж, Парламентын хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан эмэгтэй парламентын гишүүдийг үлгэр дуурайлал болгон таниулж, сурталчлах
- Бүс нутгийн болон олон улсын түвшинд парламенттай танилцах аялал хийх замаар Парламентын гишүүдийн дунд сайн туршлагыг хуваалцахад дэмжлэг үзүүлэх

## Албан тушаал, үүргийн тэгш байдлыг хангах

Парламент дахь эмэгтэйчүүдийн тооны нэгэн адил парламентын удирдах албан тушаалд эмэгтэйчүүд байх нь мөн чухал юм.

Парламентын гишүүн болон гол гишүүний хувьд эмэгтэйчүүд удирдах албан тушаал хаших, тэр утгаараа бодлогын чиглэлд нөлөөлөх, парламентын үйл ажиллагаа, практикийг өөрчлөх, бусад эмэгтэйчүүдэд үлгэр дууриалал болох, асуудалд өөр өнцгөөс хандах зэрэг эдгээр нөхцлүүд бүрдсэн тохиолдолд Жендерийн мэдрэмжтэй парламентын зарчим илүү хөгжингүй болох боломжтой.

Эмэгтэйчүүдийн манлайллыг сайжруулах, удирдах албан тушаал дахь жендерийн тэгш байдлыг хангахын тулд Парламентууд дараах арга хэмжээнээс нэг эсвэл хэд хэдэн арга хэмжээг авч хэрэгжүүлбэл зохино. Үүнд:

- Нааштай арга хэмжээ авч, дотоод журамд өөрчлөлт оруулах замаар мэргэжил чадварын хувьд эн тэнцүү эсвэл парламент дахь төлөөлөлтэй дүйцэж буй тохиолдолд Парламентад эрэгтэйчүүдээс илүү эмэгтэйчүүдэд давуу эрх олгох (хороон дарга, кабинет, удирдах зөвлөл зэрэг албан тушаалд)
- Тодорхой хугацааны давтамжтайгаар парламент дахь удирдах албан тушаалыг эрэгтэй, эмэгтэй хүмүүсээр сольж томилох
- Эрэгтэй, эмэгтэй хүнийг давхар томилох замаар парламентад хос (dual) удирдлагыг нэвтрүүлэх
- Парламент дахь эмэгтэй гишүүдийг зөвхөн эмэгтэйчүүд, хүүхэд, хүйс, гэр бүл, эрүүл мэнд, боловсролтой холбоотой хороодод бус бүх хороодод тэгш хуваарилахыг дэмжиж ажиллах
- Удирдах албан тушаалд байгаа хүмүүсийг улс төрд орохоос өмнө эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдэд тавигддаг туршлагыг үнэлэхэд ашиглагддаг шалгууруудыг өргөжүүлэхийг хөхүүлэн дэмжих

# Жендерийн тэгш байдлын тухай хууль тогтоомж, бодлогыг бэхжүүлэх

*Парламент нь жендерийн тэгш байдлын зарчмыг дэмжсэн хууль тогтоомж, бодлогыг хэрэгжүүлснээр жендерийн мэдрэмжтэй Парламент болж чадна. Жендерийн тэгш байдлыг хангах, дэмжих тухай хууль тогтоомжийг нэвтрүүлэх нь нийгэм, соёлын хүрээнд жендерийн тэгш байдлын тухай хандлагыг өөрчлөхөд томоохон түлхэц болно.*

*Парламент нь жендерийн мэдрэмжтэй стратегийн бодлого, үйл ажиллагааны төлөвлөгөө, түүнийг дэмжсэн бодлого баримтлах замаар нийгэмд үлгэр жишээ болж чадна.*

### Үндэсний хууль тогтоомж

Жендерийн тэгш байдлын талаарх нийгэм, соёлын хандлагыг өөрчлөхөд дэмжлэг үзүүлэх зорилгоор Парламентууд дараах зүйлийг хийвэл зохино:

- Жендерийн тэгш байдлыг хангах, хамгаалах хууль тогтоомж гаргах; Жендерийн тэгш байдлыг хангах тухай хууль батлагдсан боловч хуучирсан эсвэл 10 гаруй жилийн өмнө батлагдсан бол Парламентууд эдгээр хууль тогтоомжоо эргэн харж, хэрэгжилтэд нь хяналт тавих, хэрэгжүүлэхэд шаардлагатай тогтолцоо, механизмыг хөгжүүлэх.

Жендерийн тэгш байдлыг хангах хууль тогтоох бүрэн эрхийг баталгаажуулахын тулд Парламентууд дараах зүйлийг хийвэл зохино:

- Төрийн бүх бодлого, хууль тогтоомжийг хамрах хууль эсвэл механизмыг нэвтрүүлэхдээ тэдгээрийн жендерт үзүүлэх нөлөөлөл болон Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенц (CEDAW), Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, Эдийн засаг, нийгмийн эрхийн тухай олон улсын пакт зэрэг олон улсын холбогдох конвенцид заасан төрийн үүрэгт нийцэж байгаа эсэхийг хянаж, үнэлэх.

### Парламентын стратегийн бодлого болон үйл ажиллагааны төлөвлөгөө

Нийгэм дэх жендерийн тэгш байдлыг хангахад манлайлагч, үлгэр дууриалал болохын тулд Парламентууд дараах зүйлийг хийвэл зохино:

- Хүйсийн тэгш байдлын тухай бодлогыг боловсруулахдаа дараах зүйлсийг тусгана:

Энэхүү үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх үндэслэл, стратегийн чиглэлээ тодорхойлох,

Тодорхой хугацаанд жендерийн тэгш байдлыг хангах талаар Парламентаас авах тодорхой арга хэмжээнүүд,

Парламентын зохих хяналтын механизмаар тогтмол ахиц дэвшлийг нь хэмжих шалгуур үзүүлэлтүүд,

- Хүйсийн тэгш байдлын тухай бодлогыг боловсруулахдаа дараах зүйлсийг тусгана:

## **Парламентын үйл ажиллагааны болон дэмжих бодлого**

### *Хэвлэл мэдээлэл, харилцаа холбооны бодлого*

Жендерийн тэгш байдлыг дэмжихийн ач холбогдлыг сайтар таниулж, ил тод байдлыг сайжруулахын тулд парламент дараах зүйлийг хийвэл зохино:

- Зорилтот үзэгчид, гол мессеж, арга, цаг хугацааг тодорхойлсон жендерийн харилцааны стратегийг боловсруулах,
- Жендерийн тэгш байдлыг хангах чиглэлээр явуулсан үйл ажиллагаа, үр дүнгээ хэвлэл мэдээллийн хэрэгслээр, эсвэл парламентын өөрийн харилцааны суваг, цахим хуудсаар таниулан сурталчлах

### *Дарамт шахалт, ялгаварлан гадуурхалтын эсрэг бодлого*

Парламентын гишүүд, ажилчид бүх төрлийн ялгаварлан гадуурхалт, бэлгийн дарамтаас ангид орчинд ажиллах боломжийг хангахын тулд Парламент дараах зүйлийг хийвэл зохино:

- Бүх парламентын гишүүд хүндэтгэлтэй, эелдэг байх ёс зүйн дүрмийг нэвтрүүлэх, эмэгтэйчүүдийг гадуурхах аливаа хэл, зан үйлд хариуцлага тооцдог байх
- Бүх Парламентын гишүүд болон Парламентын ажилтнуудад хамаарах үндэсний хууль тогтоомжийн дагуу ялгаварлан гадуурхах, дарамт шахалт үзүүлэхийн эсрэг бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх, аливаа гомдол хүлээж авах, шийдвэрлэх боломжтой бие даасан гуравдагч байгууллага байгуулах.
- Бүхий л албан баримт бичиг, байнгын тушаалуудад ашиглаж буй албан бичгийн хэл жендерийн мэдрэмжтэй байгаа эсэхэд хяналт тавих (жишээ нь, “тэр” гэсэн эрэгтэй хүнийг илэрхийлэх төлөөний үгийг ашиглахгүй байх, эрэгтэй эсвэл эмэгтэй дарга гэхээсээ илүү Дарга гэх мэт).



“Жендерийн эрх тэгш байдлыг хангахын тулд Парламентыг өөрчлөх нь” сэдвээр Парламентын эмэгтэй, эрэгтэй дарга нарын дунд хийгдсэн хэлэлцүүлгийн нээлт, Жендерийн мэдрэмжтэй Парламентуудын тусгай хуралдаан (Кэбэк хот, 2012 оны 10-р сарын 23)

### **Парламентын стратегийн бодлого болон үйл ажиллагааны төлөвлөгөө**

Нийгэм дэх жендерийн тэгш байдлыг хангахад манлайлагч, үлгэр дууриалал болохын тулд Парламентууд дараах зүйлийг хийвэл зохино:

- Хүйсийн тэгш байдлын тухай бодлогыг боловсруулахдаа дараах зүйлсийг тусгана:

Энэхүү үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх үндэслэл, стратегийн чиглэлээ тодорхойлох,

Тодорхой хугацаанд жендерийн тэгш байдлыг хангах талаар Парламентаас авах тодорхой арга хэмжээнүүд,

# Парламентын бүхий л үйл ажиллагаанд жендерийн тэгш байдлыг хангах

*Бүх салбарт хэрэгжиж буй бодлого нь эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн тус бүрийн хэрэгцээ, шаардлага, саад бэрхшээл, тодорхой асуудлуудыг шийдвэрлэх зорилгоор тэдний чадавх, оруулсан хувь нэмрийг нь хөгжүүлэхэд тулгуурласан тохиолдолд жендерийн тэгш бус байдлыг үр дүнтэй шийдвэрлэх боломжтой.*

*Эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн эдийн засаг, нийгэм, улс төр, эрх зүйн ялгааг өөртөө багтаасан жендерийн хандлагыг парламентын үйл ажиллагаанд тусгах нь жендерийн мэдрэмжтэй өөрчлөлтийг хийх үр дүнтэй алхам болно.*

### **Жендерийн хандлагыг баримтлахыг зорих нь**

Парламент нь жендерийн тэгш байдлыг бүхий л ажилдаа тусгах, уг боломжийг бий болгох замаар жендерийн тэгш байдлыг хангах зорилтоо бодит алхам болгох хэрэгтэй. Үүнтэй холбогдуулан дараах зүйлсийг хийвэл зохино:

- Хууль тогтоомж, төсвийн талаар хэлэлцүүлэг өрнүүлэх, тэр дундаа эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, охид, хөвгүүдэд зориулсан төсөв, зардлын хуваарилалтын үр дүнгийн талаар (жендерийн тэгш байдлыг хангах талаар төсөвт суусан хөрөнгө мөнгө, түүний зарцуулалтыг хэлэлцэх тусгайлсан цаг гаргах эсвэл ээлжит бус чуулган зохион байгуулах гэх мэт).
- Жендерт суурилсан хууль тогтоомжийн үнэлгээний тодорхой удирдамж эсвэл маягт боловсруулах (жишээ нь: төсөв зэргийг багтаасан бүх хууль тогтоомжийн жендерт суурилсан хяналтын хуудас).
- Жендерийн тэгш байдлын талаар тусгай мэтгэлцээнийг ажлын дараалал, ач холбогдлын дагуу зохион байгуулах, сайд нараас жендерийн онцлогтой асуулга авах, эдгээрт эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн оролцоог хангаж ажиллахад анхаарах
- Жендерийн тэгш байдлын асуудлыг хариуцаж буй хороод бүрэн эрхээ хэрэгжүүлэх, гүйцэтгэсэн ажлаа чуулганы нэгдсэн хуралдаанд тайлагнах хангалттай цаг хугацаа, нөөцөөр хангагдаж байгаа эсэхэд анхаарах (жендерийн чиглэлээр мэргэшсэн ажилтнуудыг оролцуулан) Мөн Парламентын бусад хороодтой адил эрх, үүрэгтэй байх (жишээ нь бичгээр нотлох баримт шаардах, гэрч, сайд нарын үгийг сонсох, дүгнэлт, зөвлөмжийн талаар мэдээлэх)
- Албан бус эмэгтэйчүүдийн бүлэг ч бай, Парламентын тусгайлсан хороо ч бай жендерийн хандлагыг төлөвшүүлэх үүрэг хүлээсэн байгууллага нь хууль тогтоомжийн талаарх судалгаа, шалгалтынхаа үр дүнг Парламентын улс төрийн гол байгууллагуудад тайлагнаж болох албан ёсны механизм байгаа эсэхийг баталгаажуулах. Хэрэв тайлан ирүүлээгүй тохиолдолд шалтгааныг мэдээлдэг байх.



“Парламентад жендерийн мэдрэмжтэй соёл, дэд бүтцийг бий болгох нь” сэдэвт ажлын хэсэг, Жендерийн мэдрэмжтэй Парламентуудын тусгай хуралдаан (Кэбэк хот, 2012 оны 10-р сарын 25).

### **Жендерийн тэгш байдлыг хангах бүтэц, механизмыг бий болгох**

Жендерийн хандлага нь зарим талаараа дараах үйл ажиллагааг хамарна. Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн талаар жендерээр нь ангилсан баримт болон чанарын мэдээлэл цуглуулах; эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, охид, хөвгүүд тэдний нөхцөл байдал, боломж бололцоо, асуудал бэрхшээл болоод бусад өгөгдсөн зүйлсийн дагуу хоорондын ялгааг нь харуулсан жендерийн анализ хийх; байгууллагын хүрээнд жендерийн тэгш байдлыг хангах зорилтууд хэр зэрэг биелсэн хийгээд жендерийн харилцаанд гарсан өөрчлөлтийг хэмжих шалгуур үзүүлэлтүүд дээр тулгуурлан жендерийн мэдрэмжтэй хяналт-шинжилгээ, үнэлгээний механизмыг бий болгох.

Парламентууд өөрсдийн нөхцөл байдалд тохирсон дараах механизмуудаас нэг эсвэл хэд хэдэн механизмыг хэрэглэвэл зохистой:

- Засгийн газрын бодлого, хууль тогтоомж, төсвийг хянан шалгах үүрэгтэй Парламентын **жендерийн тэгш байдлын тусгай хороотой байх**. Уг хорооны гишүүд нь засгийн газрын хөтөлбөр, үйл ажиллагааны үр нөлөөний талаар санал бодлоо хуваалцах боломжтой хувь хүнээс эхлээд төрийн байгууллага, эрдэмтэн судлаачид, хувийн хэвшил зэрэг өргөн хүрээг хамарч болох бөгөөд уг хороо болон эмэгтэйчүүдийн үндэсний хороо, иргэний нийгмийн байгууллага (ИНБ), эрдэм шинжилгээний хүрээлэн, их дээд сургуулиуд гэх мэт байгууллагуудын хооронд нягт уялдаа холбоо бий болох нь чухал юм.

- **Парламентын бүх хороодод жендерийн асуудлыг нэвтрүүлэх;** ингэснээр тус хороодын эрэгтэй, эмэгтэй бүх гишүүд жендерийн чиглэлээр мэргэшсэн Парламентын судалгааны ажилтнуудын дэмжлэгтэйгээр өөрсдийн хэлэлцэж буй бодлого, хууль тогтоомж, төсвийн асуудалд жендерийн ойлголтыг тусгах боломжтой.
- Жендерийн тэгш байдлын асуудлаарх тусгай чиг үүрэг бүхий парламентын **эмэгтэйчүүдийн бүлэг** эмэгтэйчүүдээс (хүсвэл эрэгтэйчүүдээс) бүрдэх бөгөөд нийтээр тохирсон мөрийн хөтөлбөр дээр ажиллана. Энэхүү бүлэг нь эмэгтэйчүүдийн үндэсний холбоо, ИНБ, судалгааны хүрээлэн, их дээд сургуулиудтай нягт уялдаа холбоотой байх хэрэгтэй.
- **Парламентын даргын дэргэдэх жендерийн тэгш байдлын асуудлаарх бүлэг** нь улс төрийн төлөөлөл болох эрэгтэй, эмэгтэй парламентын гишүүдээс бүрдэх бөгөөд парламентын даргад ажлаа шууд тайлагнаж, парламентын жендерийн тэгш байдлын чиглэл, мөрийн хөтөлбөрийг тодорхойлно.
- **Жендерийн тэгш байдлын судалгааны нэгжүүд** эсвэл хамгийн сүүлийн үеийн мэдээлэл, ном, компьютер, онлайн мэдээллийн санд хандах боломжтой, жендерт суурилсан дүн шинжилгээ хийхэд тусалж чадахуйц номын сан/судалгааны ажилтнууд.

# Жендерийн мэдрэмжтэй дэд бүтэц, парламентын соёлыг бий болгох, сайжруулах

*Парламент нь бусад ажлын байрны нэгэн адил гэр бүлд ээлтэй бодлого дэд бүтцийг бий болгож, ялгаварлан гадуурхалт, дарамт шахалтаас урьдчилан сэргийлэхтэй холбоотой бодлого хэрэгжүүлэн Парламентын хөрөнгө, өмчийг тэгш хуваарилах замаар жендерийн мэдрэмжтэй зарчмуудыг баримталж нийгэмд үлгэр жишээ болж ажиллах хэрэгтэй өөрчлөлтийг хийх үр дүнтэй алхам болно.*

### Ажил, гэр бүлийн тэнцвэрт байдлын зохицуулалт

Ажлын байрны бодлого, дэд бүтэц нь эрэгтэй, эмэгтэй парламентын гишүүдэд тулгарч буй орчин үеийн ажил, гэр бүлийн бодит байдлыг тусгаж дэлхий даяар эмэгтэйчүүд ахуйн ажилд харьцангуй их цаг зарцуулсаар байгааг хүлээн зөвшөөрч, Парламентууд нь:

- Хуралдааны цагийг өөрчлөх (жишээ нь: шахуу хуралдаануудыг тогтоох, эрт эхлэх хуваарь гаргах, санал хураалтаас хоцрохоос сэргийлэх, хуралдааны цагийг сургуулийн хуваарьтай уялдуулах гэх мэт). Парламентын гишүүд сонгогчидтойгоо эргэх холбоотой байж, гэр бүлийнхэнтэйгээ илүү их цагийг өнгөрөөх боломж бүрдэнэ,
- Парламентын гишүүдийг чуулганы хуралдааны үеэр хүүхдүүдтэйгээ ойр байх боломжийг хангаж өгөх зорилгоор Парламентын ордонд хүүхэд асрах төв, гэр бүлийн өрөө гаргаж өгөх,
- Парламентын гишүүд (эрэгтэй, эмэгтэй аль аль нь) хүүхдээ төрөх үед хүүхэд асрах чөлөө авах эрхтэй болохыг баталгаажуулах,
- “Албан ёсны ажил”-аас гадна хүүхэд асрах чөлөө, эцэг эхийн амралтыг чуулганы хурал таслах зүй ёсны шалтгаан болгон хүлээн авах гэх мэт урт хугацааны амралтыг хэрэгжүүлэх боломжгүй тохиолдолд өөр хувилбаруудыг авч үзэх,
- Хөхүүл хүүхэдтэй парламентын гишүүдэд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр санал өгөх эсвэл өөр аргаар санал өгөх боломжийг олгох.

### Ялгаварлан гадуурхалт, дарамтаас ангид ажлын байрны соёлыг төлөвшүүлэх

Аюулгүй, хүндэтгэлтэй, алагчлалгүй, дарамтгүй ажлын байрыг бий болгохын тулд парламент дараах зүйлийг хийвэл зохино:

- Парламентын уламжлал, хувцаслалтын хэв маяг, үг хэлэх хэлбэр, түгээмэл хэрэглэгддэг хэл, ёс заншил болон дүрэм журмуудад жендерт суурилсан дүн шинжилгээ хийх.

- Парламентын бүх гишүүдэд жендерийн талаарх мэдлэг олгох сургалт семинар болон шинэ гишүүдэд жендерийн мэдрэмжтэй байх танилцуулга сургалт зохион байгуулах. Энэ нь эмэгтэй парламентын шинэ гишүүдэд хувийн зөвлөгөө өгөх, эмэгтэйчүүдийг туршлагатай парламентын гишүүдтэй (эрэгтэй эсвэл эмэгтэй) дадлагажуулах эсвэл парламентын орчинд хэрхэн мэргэжлийн түвшинд асуудалд хандах талаар ахмад эмэгтэй парламентын гишүүдээс илтгэл сонсох зэрэг хэлбэртэй байж болно.

### **Зохистой нөөц, боломжоор хангах**

Парламентын байгууламж, хэрэгсэл, нөөц эрэгтэй, эмэгтэй хүмүүст тэгш хуваарилагдсаныг баталгаажуулахын тулд парламент дараах зүйлийг хийвэл зохино:

- Парламентын гишүүдэд олгосон бүх байгууламжид жендерийн үнэлгээг хийх
- Парламентын гишүүдэд олгох тэтгэмж, томилолтын зардлыг ил тод, тэгш, нээлттэй байлгаж, Парламентын төлөөлөгчдийн жендерийг аль болох тэнцвэртэй байдлаар шийдэх.



“Парламентын бүх ажилд жендерийг тусгах” ажлын хэсэг, Жендерийн мэдрэмжтэй Парламентуудын тусгай хуралдаан (Кэбэк хот, 2012 оны 10-р сарын 25).

# Жендерийн тэгш байдлын талаарх үүрэг хариуцлагыг эрэгтэй, эмэгтэй бүх парламентын гишүүд жигд хуваалцаж байх

*Бүхий л бүтэц, арга барил, үйл ажиллагаандаа жендерийн тэгш байдлыг хангасан жендерийн мэдрэмжтэй Парламентыг бэхжүүлэх нь эрэгтэй парламентын гишүүдийн дэмжлэг, оролцоогүйгээр хэрэгжих боломжгүй. Эрэгтэйчүүдийн нийгэм дэх хандлага, жендерийн талаарх мэдлэгийг дээшлүүлснээр жендерийн тэгш байдлын талаар эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хамтын ажиллагаа улам нэмэгдэх боломжтой.*

Парламент нь дээрх хамтын ажиллагааг дэмжих дараах стратегийг нэвтрүүлэх нь зүйтэй. Үүнд:

- Жендерийн тэгш байдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрэгтэй, эмэгтэй парламентын гишүүдээр хамтран удирдуулах үйл ажиллагааг дэмжих,
- Жендерийн тэгш байдлын хорооны дарга ба/эсвэл дэд даргаар эрэгтэй, эмэгтэй парламентын гишүүдийг хамтад нь томилох,
- Эрэгтэйчүүдийн сонирхсон жендерийн бодлогын асуудлаар хороо байгуулах.
- Олон улсын эмэгтэйчүүдийн өдөр, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох олон улсын өдөр зэрэг жендертэй холбоотой парламентын арга хэмжээнд эрэгтэйчүүдийг оролцуулахыг дэмжих,
- Аялал жуулчлал (томилолт), олон улсын төлөөлөгчдөд жендерийн тэгш байдал хангагдаж байгаа эсэхэд анхаарах,
- Эрэгтэй парламентын гишүүдэд зориулсан жендерийн мэдрэмжтэй сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх.

Жендерийн мэдрэмжтэй Парламентуудын тусгай хуралдаан (Кэбэк хот, 2012 оны 10-р сарын 26).



# Улс төрийн намуудыг жендерийн тэгш байдлын төлөө тэмцэгч байхыг дэмжих

*Улс төрийн намууд нь ихэнхи тохиолдолд улс төрийн зохион байгуулалтын зонхилох хэлбэр байдаг бөгөөд жендерийн тэгш байдлыг хангах чиглэлээр эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн хууль тогтоох хөтөлбөрийг хэрэгжүүлэх гол механизм болдог.*

Парламент улс төрийн намуудыг жендерийн мэдрэмжтэй дараах арга хэмжээг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлбэл зохистой:

### **Эмэгтэйчүүдийн тоог түвшнээр нь дараах байдлаар нэмэгдүүлэх:**

- Эмэгтэйчүүдийн парламент дахь оролцоог нэмэгдүүлэх, хэвээр байлгахыг дэмжих түр зуурын тусгай арга хэмжээг авч үзэх,
- Гүйцэтгэх байгууллагын бүх удирдах албан тушаалд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг адил тэгш томилох,
- Сонгогдсон парламентын гишүүдийг сонгуульд нэр дэвших хүсэлтэй эрх бүхий эмэгтэйчүүдтэй хослуулах, сонгуулийн компанит ажил, хэвлэл мэдээллийн харилцаа зэрэг төрөл бүрийн чиглэлээр сургалт явуулах,
- Сонгон шалгаруулалтад оролцох болон сонгогдсон эмэгтэйчүүдийг сонгон шалгаруулж авах, түвшинг сайжруулах зорилгоор сонгуульд нэр дэвшигч болон сонгогдсон эмэгтэйчүүдийг дэмжих нэгдсэн сүлжээ бий болгох.

### **Жендерийн мэдрэмжтэй уулзалтын зохион байгуулалт, ажлын практикийг дараах байдлаар бий болгох:**

- Гэр бүлийн бусад үүрэг хариуцлагатай давхцахгүй байхаар уулзалтын цагийг товлох.
- Гэр бүлийн бусад ажил, үүргийг биелүүлэх шаардлагыг анхаарч уулзалтын товлосон үргэлжлэх хугацааг уян хатан байлгах.

### **Жендерийн тэгш байдлыг хангах механизмыг дараах байдлаар хөгжүүлнэ:**

- Жендерийн тэгш байдлын ерөнхий төлөвлөгөөг жендерийн тэгш байдлыг хангах тодорхой стратеги болон хэрэгжилтийг хянах, явцыг үнэлэх зорилготой хороодыг байгуулах.
- Улс төрийн намуудыг баримт бичигтээ жендерийн мэдрэмжтэй үг хэллэг ашиглахыг дэмжих.

**Парламентын хорооны албан тушаалыг эрэгтэй, эмэгтэй гишүүдийн дунд тэгш хуваарилах нь:**

- Гишүүдийн олон талт чадвар, ажлын туршлага, хорооны үүрэг даалгаврын онцлогтой уялдуулан хорооны гишүүд болон тэдгээр хороодын удирдах албан тушаалд томилох ил тод аргыг хэрэгжүүлэхэд намуудыг хөхүүлэн дэмжих. Мэргэжил, чадварын хувьд эн тэнцүү байх тохиолдолд эмэгтэйчүүдэд давуу тал олгож болно.



Жендерийн мэдрэмжтэй Парламентууд:  
Сайн туршлагын тухай дэлхийн тойм

# Парламентын ажилтнуудын дунд жендерийн мэдрэмж, жендерийн тэгш байдлыг нэмэгдүүлэх

*Жендерийн мэдрэмжтэй Парламент нь гишүүдийнхээ төдийгүй тэднийг дэмждэг олон ажилтнуудын хувьд жендерийн тэгш байдлын төлөө тэмцэгчид юм. Парламентын тамгын газар нь ажлын байрны соёл, дэд бүтцээ эргэн харж, жендерийн тэгш байдлыг хангах зорилтоо хэрэгжүүлэхэд бүх ажилтнууд Парламентад дэмжлэг үзүүлэх боломжтой байх нөхцөлийг бүрдүүлэх нь чухал юм. Үүнтэй холбогдуулан Парламент, түүний удирдлага дараах зүйлсэд анхаарах нь зүйтэй:*

- Парламентын нийт ажилтнуудад хамаарах ялгаварлан гадуурхах, дарамт шахалтын эсрэг бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх, мөн гомдол санал хүлээж авах, шийдвэрлэх боломжтой бие даасан гуравдагч байгууллагыг байгуулах,
- Парламентын тамгын газар дахь эмэгтэйчүүдийн тоо, албан тушаалыг үнэлэх,
- Мэргэжил, ур чадварын түвшин тэнцүү, эмэгтэйчүүдийн удирдлагын төлөөлөл хангалтгүй байгаа тохиолдолд Парламентын албан тушаалд эрэгтэйчүүдээс илүү эмэгтэйчүүдийг томилох бодлого хэрэгжүүлэх боломжийг шалгаж нягтлах үүрэг бүхий хороо байгуулах эсвэл одоо байгаа аль нэг хороонд даалгах,
- Жендерийн тэгш байдлын зарчмуудыг, мөн жендерийн мэдрэмжтэй Парламент яагаад хүн бүрд ашигтай байдгийг тайлбарлах зорилгоор Парламентын бүх ажилтнуудад жендерийн мэдлэг олгох сургалт, семинар зохион байгуулах,
- Парламентын ажилтнуудыг хууль тогтоомж, төсөв болон бодлогод жендерт суурилсан дүн шинжилгээ хийж сургахад чадавхжуулах.

## Парламентад жендерийн мэдрэмжтэй шинэчлэлийг санаачлан хэрэгжүүлэх нь

*Жендерийн мэдрэмж бол бүх Парламентын хичээж хүрэх ёстой зорилго юм. Энэхүү зорилгод хүрэхийн тулд Парламентууд үндэснийхээ онцлогт тохирсон дараах үндсэн элементүүдийг агуулсан үйл ажиллагааг боловсруулах ёстой.*

### Үнэлгээ

Өөрийн жендерийн мэдрэмжийн түвшинг үнэлэх сонирхолтой Парламентуудын хувьд:

- ОУПХ-ны жендерийн мэдрэмжийн өөрийгөө үнэлэх хэрэгслийг ашиглах; Өөрийгөө үнэлэх зорилго нь Парламентуудыг түвшин тогтоож эрэмбэлэх бус харин олон улсын шилдэг туршлагын дагуу өөрсдийн давуу болон сул талуудыг тодорхойлоход нь туслах юм. Энэхүү хэрэглүүр нь Парламентын гишүүдийн дунд хэлэлцүүлэг өрнүүлэх боломжийг бүрдүүлэх ба жендерийн тэгш байдлыг Парламентын соёл, үйл ажиллагаанд хэрхэн хэрэгжиж байгаа тухай асуултад хариулахад тусална.
- Өөрийн жендерийн мэдрэмжийн түвшинг үнэлэхийн тулд өөрсдийн дотоод аудит, бизнесийн бусад хяналт, хороо зэрэг бүтцийг ашиглах. Энэ тохиолдолд, иргэний нийгмийн бүлгүүд, эмэгтэйчүүдийн үндэсний хороо, судалгааны хүрээлэнгүүд зэрэг гадны оролцогч талуудыг урьж, жендерийн мэдрэмжийн түвшний талаарх санал бодлоо тус хороонд хуваалцаж, өөрчлөлт хийх зөвлөмжийг боловсруулж болно. Дараа нь тус хороо нь өөрийн дүгнэлт, зөвлөмжийг чуулганы нэгдсэн хуралдаан эсвэл Парламентын удирдлагад танилцуулж,

### Хэрэгжилт

Ашигласан аргаас үл хамааран Парламент нь жендерийн тэгш байдлын ач холбогдлыг ойлгож, энэ зорилгыг сонгогчдод төдийгүй гишүүддээ хэрхэн таниулж сурталчлах нь маш чухал юм.

Дүгнэлт дээр үндэслэн Парламент нь өөрсдийн үндэсний нөхцөл байдалд тохирсон тодорхой зорилт, арга хэмжээ, хэрэгжүүлэх хугацаа бүхий шинэчлэлийн төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх боломж бүрдэнэ. Үүний тулд хүн хүч, баг хамт олныг баталгаажуулах шаардлагатай болно.

## **Хяналт**

Парламент нь жендерийн мэдрэмжтэй Парламентын үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт, жендерийн мэдрэмжтэй Парламентын зорилгод хүрэх хүчин чармайлтад тусгайлан хяналт тавих чиг үүрэг бүхий бүтцийг тодорхойлох хэрэгтэй.

## **Урамшуулал**

Парламент нь хийж байгаа шинэчлэл, гарсан үр дүнгээ ил тод байлгах хэрэгтэй. Парламент нь олон улсын Парламентын бүх байгууллагад жендерийн тэгш байдлын зарчмыг сурталчлах, эмэгтэйчүүдийн тэгш оролцоог дэмжих чиглэлээр олон улсын түвшинд арга хэмжээ авах хэрэгтэй.

Улс төрийн хүсэл эрмэлзэл, тууштай байдал нь энэ бүхэнд хүрэхэд чухал нөлөөтэй.

# Жендерийн мэдрэмжтэй Парламентыг дэмжихэд ОУПХ-ны үүрэг, оролцоо

Сүүлийн 30 жилийн хугацаанд ОУПХ нь жендер болон Парламентын тухайд өндөр чанартай, үйл ажиллагаанд чиглэсэн судалгааг идэвхтэй хийж ирсэн. ОУПХ нь Парламентын гишүүдийн жендерийн мэдрэмжтэй байх хүчин чармайлтыг дэмжихэд онцгой анхаарал хандуулдаг ба энэхүү төлөвлөгөөгөөр дамжуулан:

## Жендерийн мэдрэмжтэй Парламентыг дэмжихэд манлайлах үүрэгтэй байх:

- Гишүүдийнхээ дунд төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд идэвхтэй оролцох ба төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад чуулганаар дамжуулан тогтмол лавлаж шалгах,
- Төлөвлөгөөг цахим хуудас, жендерийн түншлэлийн хөтөлбөр, техникийн бусад мэдээлэх арга хэрэгслээр дамжуулан ил тод, нээлттэй байлгах,
- Үндэсний бүх Парламентад 2030 он гэхэд бие даасан жендерийн мэдрэмжтэй байх түвшний үнэлгээг явуулахад дэмжлэг үзүүлэх,
- Парламентын үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах, Парламентын мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийг бэхжүүлэхэд чиглэсэн хяналтын тогтолцоог бий болгоход дэмжлэг үзүүлэх,
- Жендерийн мэдрэмжтэй Парламентыг дэмжих чиглэлээр бүс нутгийн түнш байгууллагууд болон холбогдох олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагаагаа бэхжүүлэх,

## Жендерийн тэгш байдал, жендерийн тэгш байдлыг хангах талаар дотоод чадавхыг бэхжүүлэх:

- Жендерийн үндсэн чиг хандлагын стратегийг хэрэгжүүлэх,
- ОУПХ-ны нийт ажилтнуудад зориулсан мэргэжил дээшлүүлэх сургалт жендерийн мэдрэмжтэй байх,
- Тамгын газрын үйл ажиллагаанд жендерийн тэгш байдлыг хангаж ажиллуулах,
- хамтын ажиллагаагаа бэхжүүлэх,

## Жендерийн тэгш байдал, жендерийн тэгш байдлыг хангах талаар дотоод чадавхыг бэхжүүлэх:

- Парламентын жендерийн мэдрэмжийн байдалд тогтмол хяналт тавьж ажиллахыг жендерийн түншлэлийн бүлэгт даалгах
- Техникийн туслалцааны бүх үйл ажиллагаанд жендерийн асуудлыг тусгасан байх
- Жендерийн мэдрэмжтэй Парламентын талаарх ажлыг олон улсын бүх форумд таниулан сурталчлах

## Жендер\*

Эрэгтэй, эмэгтэй хүйстэй холбоотой нийгмийн шинж чанарууд ба эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, охид, хөвгүүдийн хоорондын харилцаа юм. Эдгээр шинж чанар, харилцаа нь нийгэмд бий болж, нийгэмших замаар хөгжиж байдаг. Хүйсийн тухай ойлголт нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн шинж чанар, авьяас чадвар, болзошгүй зан үйлийн талаарх хүлээлтийг агуулах бөгөөд нийгмийн харилцаанд ашиглагдахдаа нийгэмд бий болсон үүргийг илэрхийлж байдаг. Хүйс ба жендер нь ижил утгатай биш юм. Хүйс нь бие физиологийн ялгааг хэлдэг бол жендер нь нийгмийн ялгааг хэлэх бөгөөд хүйсийн баримжаа, үүрэг, харилцаа нь нийгмээс хамаарч байдаг тул өөрчлөгдөх боломжтой.

## Жендерийн хандлага\*

Эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн үзүүлэх нөлөөллийг бүхий л түвшинд, бүх салбарт хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр зэрэгт үнэлж, харгалзан үзэх үйл явц юм. Энэхүү хандлагыг бодлого, хөтөлбөрийн шийдвэр, институтийн бүтэц, нөөцийн хуваарилалтын төвд жендерийн асуудлыг тавьсан стратеги гэж ойлгож болно. Парламентын үйл ажиллагаанд жендерийн тэгш байдлыг тусгах нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хэрэгцээ, ашиг сонирхолд нийцсэн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх, хяналт тавихад хувь нэмэр оруулна.

## Жендерийн мэдрэмжтэй Парламент\*

Бүтэц, үйл ажиллагаа, арга барилаараа эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хэрэгцээ, сонирхолд нийцсэн хариу үзүүлдэг Парламентыг хэлнэ. Жендерийн мэдрэмжтэй Парламент нь эмэгтэйчүүдийн бүрэн оролцоонд саад болж буй аливаа бэрхшээлийг арилгаж, нийгэмд эерэг үлгэр жишээ болдог.

## Жендерийн мэдрэмжтэй төсөв төсөвлөх\*

Эдийн засгийн бодлого боловсруулж, төсөвлөхөд жендерийн асуудлыг голчлон тусгахад чиглэсэн арга барил юм. Жендерийн төсөв гэдэг нь зөвхөн эмэгтэйчүүдэд зориулсан зардлыг хэлэхгүй бөгөөд төсвийн хуваарилалт, үр дагавар нь эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн хэрэгцээнд нийцэж байгаа эсэхийг баталгаажуулахын тулд аюулгүй байдал, эрүүл мэнд, боловсрол, олон нийтийн ажил зэрэг тал бүрийн асуудлуудын төсвийг жендерийн үүднээс авч үзэхийг хэлнэ.

## Жендерт суурилсан хүчирхийлэл\*\*

Тухайн хүний жендертэй холбоотой нийгэм, соёлын хүлээлтээс үүдэж түүний эсрэг ямар нэг төрлийн хүч хэрэглэхийг (хүчирхийлэл, заналхийлэл, албадлага, заль мэх, хууран мэхлэлт, соёлын хүлээлт, зэвсэг, эдийн засгийн нөхцөл) оролдсон буюу заналхийлсэн бие махбодь,

оюун санаа болон нийгмийн хүчирхийллийн хэлбэр юм. Жендерт суурилсан хүчирхийлэлтэй тулгарсан хүн нь нийгэм, бие махбод, сэтгэл зүйн ноцтой үр дагаваргүйгээр уг хүчирхийллээс зайлсхийх эсвэл өөр сонголт хийх боломжгүй болдог. Үүнд бэлгийн хүчирхийлэл, бэлгийн дарамт, бэлгийн мөлжлөг, эрт гэрлэх эсвэл албадан гэрлэх, хүйсээр ялгаварлан гадуурхах, үгүйсгэх (жишээ нь боловсрол, хоол хүнс, эрх чөлөө) болон эмэгтэй хүний бэлэг эрхтнийг зэрэмдэглэх зэрэг олон хэлбэрүүд багтана.

\* Тодорхойлолтын эх сурвалж нь: НҮБ/OSAGI, НҮБХХ, ЮНЕСКО, Ардчилсан засаглал дахь эмэгтэйчүүдийн эрх ба жендерийн тэгш байдлыг хангах, Нью-Йорк, 2007 он ба ОУПХ, Улс төр дэх тэгш байдал: Парламент дахь эмэгтэйчүүд болон эрэгтэйчүүдийн судалгаа, Женев, 2008.

\*\* Эдгээр тодорхойлолтуудыг НҮБ-ын ЭМЭГТЭЙЧҮҮД, Охидын эсрэг хүчирхийллийг таслан зогсоох виртуал мэдлэгийн төв (2010.09.19-н байдлаар)-өөс авч ашигласан болно.

## ОУПХ-ны Жендэрийн түншлэлийн хөтөлбөр нь Парламентуудыг жендэрийн мэдрэмжтэй болгохоор гаргаж буй хүчин чармайлтыг дараах байдлаар дэмждэг.

- Сайн туршлагын харьцуулсан мэдээлэл, жишээг цуглуулах;
- Парламентын жендерийн мэдрэмжийн түвшинг үнэлэх арга хэрэгслийг боловсруулах (Үнэлгээний хэрэгсэлүүд: [www.ipu.org/english/surveys.htm#gender-toolkit](http://www.ipu.org/english/surveys.htm#gender-toolkit));
- Мэргэжилтнүүд, мэдээлэл, хэрэгслийг бэлэн байлгах замаар үнэлгээний ажлуудыг зохион байгуулах;
- Харьцуулсан сайн туршлага болон мэргэжилтнээр хангах замаар шинэчлэлийн төлөвлөгөөг боловсруулах;
- Бүс нутгийн болон үндэсний түвшинд семинар, зөвлөгөөн зохион байгуулах замаар жендерийн мэдрэмжтэй Парламентын талаар мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх;
- Жендерийн асуудлаар тусгайлсан чадавхжуулах хөтөлбөр бэлдэж Парламентын гишүүд болон Парламентын ажилтнуудыг хамруулах;
- Эмэгтэйчүүдийн бүлгийн болон/эсвэл жендерийн асуудал эрхэлсэн байнгын хороодын чадавхи, арга хэрэгсэл, ажлын арга барилыг сайжруулах замаар дэмжих;
- Жендэртэй холбоотой хууль тогтоомж болон/эсвэл дотоод журам боловсруулахад зөвлөгөө өгөх.







**Inter-Parliamentary Union**

For democracy. For everyone.

**T** +41 22 919 41 50

**F** +41 22 919 41 60

**E** [postbox@ipu.org](mailto:postbox@ipu.org)

Chemin du Pommier 5  
Case postale 330  
1218 Le Grand-Saconnex  
Geneva – Switzerland  
[www.ipu.org](http://www.ipu.org)